



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/222

Мандалговь

Мотоциклийн хөдөлгөөнийг түр хугацаагаар
хориглох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.9, Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүйтний улирал эхэлж, хотын төвийн замд халтиргаа, гулгаа үүсч, замын хөдөлгөөнд оролцогчдод аюултай нөхцөл байдал бий болж байгаатай холбогдуулан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Мандалговь хотын төвийн замаар мотоцикльтой хөдөлгөөнд оролцохыг 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл түр хязгаарласугай.

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар иргэдэд сурталчлан, захирамжид хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн дарга цагдаагийн хошууч (Б.Батгэрэл) Цагдаагийн хэсгийн байцаагч (М.Мөнхбат, Б.Хүслэн, Б.Батбаяр) багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ